*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН АЯЛЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХӨГЖҮҮЛЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН БААТАРЫН ОТГОНБИЛЭГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхлэх дуусах хугацаа | Биелэлт-ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АЖЛЫН ХҮРЭЭНД”** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ-1.1:** “Улаанбаатарын өвлийн наадам-2024” арга хэмжээний зохион байгуулалтад орж ажиллах | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | “Улаанбаатарын өвлийн наадам-2024” арга хэмжээний үеэр тайз дэлгэцээр гарах бичлэгүүд, тайзны арын болон нэмэлт хулдаасан хэвлэлүүд, Улаанбаатар бичиглэл гэрийн доторх эд зүйлсийг зөөж тээвэрлэх, гэр бүлийн тэмцээнийг хөтлөн явуулах, сайн дурын ажилчдыг ажлуулах, тугны суурь түрээслэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. | 2024.01.27 2024.01.28 | 100% |
| 2. | **Арга хэмжээ-1.2:** “Улаанбаатарын өвлийн явган аяллын фестиваль” арга хэмжээг зохион байгуулах | Арга хэмжээнд оролцогч, сонирхогчдын тоо | - | 250 | “Улаанбаатар өвлийн явган алхалт 2024” арга хэмжээг “Монголын явган алхалтын холбоо” ТББ-тай хамтран явган алхалтыг 2024оны 03 дугаар сарын 02-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Туул голын цэцэрлэгт хүрээлэн хүртэлх маршрут, 2024оны 03 дугаар сарын 03-ний өдөр Олон улсын хүүхдийн Найрамдал төвөөс Жавхлант өртөө хүртэлх маршрут замын дагуу анх удаа амжилттай зохион | 2024.03.03 2024.03.04 | 100% |

98

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан. Тус арга хэмжээнд нийслэл хотын алхагчдаас гадна 10-н аймгийн нийт 300гаруй явган алхагчид зорин ирж оролцсон. Арга хэмжээний үеэр Мөсний шагайн харвааны тэмцээн, Олс таталтын тэмцээн, урлагийн тоглолт зэргийг зохион байгуулсан. | | |
| 3. | **Арга хэмжээ-1.3:** Улаанбаатар хотын аяллын шинэ бүтээгдэхүүнийг бий болгож хэвлэмэл мэдээллийн танилцуулга гаргаж олон нийтэд сурталчлан ажиллах | Гүйцэтгэлийн хувь | - | 100% | Монгол улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотод зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, гадаад дотоодын жуулчдыг татах тусгай сонирхлын аяллын бүтээгдэхүүнийг шинээр бий болгох, эко аялал жуулчлалыг дэмжиж “Улаанбаатар хот 360 хөтөч” номыг гаргаж иргэд жуулчдад хүргэхээр төслийн ажлыг судлан Хүрээлэн төслийн баг бүрэлдэхүүнтэй хамтран ажиллахаар 2024 оны 03 дугаа сарын 05-ны өдөр нийслэлийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан нийслэлийн удирдлагуудаас санал авч байна.<br>• Уг номыг гаргаснаар дараах аяллын бүтээгдэхүүнүүдийг бий болгох зорилтыг тавин ажиллаж байна.<br>• 1.Гэрэл зургийн аялал<br>• 2.Ховор ан амьтан ажиглах аялал<br>• 3.Явган аяллыг хөгжүүлэх<br>• 4.Дугуйн аялал<br>• 5.Бартаат замын<br>• 6.Цэцэг ажиглах аялал гэх мэт ховор ан амьтан, байгалийн онцлог нөөцөд тулгуурлан 5 чиглэлд 11 төрлийн | 2024.03.09<br>2024.03.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор мэдээлэл агуулсан аяллын товхимол болох юм.<br>Мөн Улаанбаатарын өвлийн явган аяллын фестиваль" арга хэмжээг анх удаагаа 2 маршрутын дагуу зохион байгуулсан. Улаанбаатар хотын тойрон аяллын 3-н маршрутыг шинэчилэн гаргасан. Нийслэлийн засаг даргын тамгын газартай хамтран "Ирээдүйн хотын иргэн" төслийн хүрээнд Улаанбаатар хотын Ерөнхий боловсролын 8-н сургуулийг нийт 640 гаруй сурагчдыг 8-н өөр маршрутын дагуу Сити тур аяллыг хийсэн. | | |
| 4. | **Арга хэмжээ-1.4:**<br>Дотоодын аялагчдад зориулсан өвлийн аяллын төрлийг судлах, бий болгох жуулчдад зориулсан эвент арга хэмжээний бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хариуцах ажлыг зохион байгуулах | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх саналыг боловсруулан Tourism.ub.gov.mn сайт Улирлын хямдрал цэсийг үүсгээд байна. Нийслэлийн Аялал жуулчлалын газар page хуудсаар постер болгон олон нийтэд сурталчлан ажиллаж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээ болон үйл ажиллагаандаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудад 1+1 урамшуулал, 10-50 хувь хүртэл хөнгөлөлт үзүүлэх боломжтой 9 салбарын 62 ААН-ийн 500 гаруй бүтээгдэхүүнийг нэгтгэн хямдралтай аян өрнүүлж байна. Мөн Улаанбаатар хот орчимд өвлийн улиралд хөгжүүлж болох аяллын төрлүүд буюу нохой чарганы аялал, параглайдинг, мөсний загасчлал, цана чаргаар гулгах, амралт чөлөөт цагаа | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өнгөрүүлэх газруудыг үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, хувь хүнтэй уулзаж санал солилцсон. | | |
| 5. | **Арга хэмжээ-1.5:** “Хөдөлмөрийн яармаг” арга хэмжээг зохион байгуулах | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Хөдөлмөрийн яармагийг 04 дүгээр сарын 24-ний өдөр “Нийслэлийн иргэний танхим”-д болон 05 дугаар сарын 25-26-ны өдрүүдэд “Улаанбаатар травэл экспо-2024” аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр 10:00-17:00 цагийн хооронд Мишээл экспо төвд 16 дэх жилдээ зохион байгуулав. Хөдөлмөрийн яармагийн үеэр бүртгэлтэй ажлын байранд шууд зуучлах, нээлттэй ажлын байр зарласан жуулчны бааз, тур оператор, зоогийн газар, зочид буудлын ажил олгогчид ажилд бүртгэж 900 гаруй иргэнд мэдээлэл өгсөн. Сул ажлын байрын зарын газрын пэйж хуудсанд байршуулж олон нийтэд сурталчилж нийт 5155 хүнд хүргэж ажилласан. Тус арга хэмжээг “Монголын Мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо ТББ” , “Улаанбаатар Аялал жуулчлалын холбоо ТББ”-тай хамтран жуулчны бааз, зочид буудал, зоогийн газар зэрэг аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас нээлттэй ажлын байруудын захиалгыг авч нэгтгэн бүртгэлтэй ажлын байранд шууд зуучлах, нээлттэй ажлын байранд бүртгэл хийж ажилласан. | 2024.04.01<br>2024.11.01 | 100% |
| 6. | **Арга хэмжээ-1.6:** “Улаанбаатар олон улсын явган аяллын фестиваль” зохион байгуулах | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | “Улаанбаатар олон улсын явган аяллын фестиваль”-ийг 2024 оны 08 дугаар сарын 23-28-ны өдрүүдэд Налайх, Баянзүрх дүүргүүдэд явган алхалтын тохижуулсан 3 замаар зохион байгуулахаар | 2024.08.23-<br>2024.08.28 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монголын явган алхалтын холбоо, Монгол Олле нийгэмлэгтэй хамтран уулзалт хийв. Фестивальд Монгол Улсын 21 аймаг болон явган алхалтын холбоодын гишүүд сайн дурын алхагчид 300 гаруй, ОХУ-аас 35, БНХАУ-ын Тайвань Улсаас 12, БНСУ-аас 60 гаруй, БНЧУ-аас 4, Филипин-4, 2, АНУ-аас 2, БНКУ-аас 4 зэрэг алхагчид хамрагдан 2024 оны 08 дугаар сарын 23-28-ний өдрүүдэд явган алхалтын тохижуулсан 2 замуудад зохион байгуулагдав. 8 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хотод шинэ алхалтын замыг нээж тэмдэгжүүлэлт хийж алхалтыг зохион байгуулав. 1 дэх өдөр Өглөө Жанжин Д.Сүхбаатарын талбайгаас Налайх дүүргийн 6-р хороо Өгөөмөрийн ам Горхи тэрэлжийн байгалын цоцолбор газарт байрлах Монгол Олле 3-р замаар эхэлж 17 км замыг туулав. 2 дахь өдөр Налайх дүүргийн 6-р хороо Чингис Уул, Горхи тэрэлжийн байгалын цоцолбор газарт байрлах Монгол Олле 2-р замаар эхэлж 12 км замыг туулав. 3 дахь өдөр Улаанбаатар хотын төв талбай жанжин Д.Сүхбаатарын талбайгаас эхэлж Баянзүрх дүүргийн 11-р хороо Скай ресорт цаныг бааз хүртэл нийт 11 км замыг туулав. "Улаанбаатар олон улсын явган аяллын фестиваль"-ийн мэдээллийг 2024 оны 7-р сарын 20-ний өдрөөс цуврал мэдээ бэлтгэж, 38 гаруй төрлийн мэдээ, мэдээллийг олон нийтийн 23 гаруй цахим хуудсанд байршууллаа. Нийт 48 удаагийн нийтлэл оруулж 210 860 хүнд арга хэмжээний мэдээлэл хүрсэн байна. "Улаанбаатар олон улсын явган аяллын фестиваль" арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын явган | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | алхалтын холбоо ТББ хамтран нийт 63,056,000 төгрөгийн төсөвтэйгөөр зохион байгуулсан. Арга хэмжээнд зарцуулагдах зардлыг холбогдох байгууллага, иргэдтэй ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажлын үр дүнг явцын хяналт болон гэрээт ажил хүлээлцсэн акт, протоколыг үндэслэн хүлээлцэв. төсвийг дараах байдлаар зарцуулав | | |
| 3.4.1.3. Жуулчдын зорин очих газрын дэд бүтцийг сайжруулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ. | | | | | | | |
| 7. | **Арга хэмжээ-2.1:** Улаанбаатар хотын тойрон аяллын "Сити тур" төслийг үргэлжлүүлэх | Арга хэмжээнд оролцогч | 5000 | 5052 | Сити тур төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 01,02-ний өдрүүдэд 2 автобусанд шаардлагатай засвар үйлчилгээг хийлгэж 4 дүгээр сарын 02-ний өдрөөс 2 жолооч, 2 хөтөчтэйгөөр эхлүүлэн ажиллаж байна. 11 сарын байдлаар нийт 82 удаагийн аялал зохион байгуулж 6380 гаруй дотоод, гадаадын аялагч хамрагдаж, 28,280,000 төгрөгийн орлогыг төвлөрүүлээд байгаа бөгөөд Нийслэлийн засаг даргын 2024 оны А/243 дугаар захирамжаар батлагдсан Хүүхэд өсвөр үеийнхэнд зориулсан "Ирээдүйн хотын иргэн" төслийн хүрээнд НЗДТГ-ийн Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран 2024 оны 09 дүгээр сараас 11 дүгээр сарын 29-ний өдрийг хүртэл хотын аяллыг төлөвлөн хийж байна. Аялал дууссаны дараа НЗДТГ-аас захиалгат гэрээний дагуу 8,000,000 сая төгрөг шилжиж орж ирснээр тус газар нь сити тур төслөөр 36,280,000 төгрөгийг орлогыг бүрдүүлээд байна. | 2024.06.01 2024.12.01 | 100% |
| 8. | **Арга хэмжээ-2.2:** Налайх дүүрэг дэх "Нэг жуулчин-нэг мод" жуулчны төгөлд мод тарих арга хэмжээг зохион байгуулах | Тарьсан модны тоо | 200 | 250 | Монголын Мэргэжлийн Аялал жуулчлалын холбоо, Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Цолмон трэвел ХХК-тай хамтран "Нэг жуулчин-Нэг мод" жуулчин төгөлд мод тарих уриалгыг аялал | 2024.05.01 2024.10.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | жуулчлалын тур оператор байгууллагуудад түгээн ажиллав. Арга хэмжээний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр “ЖУУЛЧИН ТӨГӨЛ”-д Монос, Шинэс, Хайлаас, Тавилгана зэрэг долоон зүйлийн 130 гаруй мод тарьсан. Мөн 06 дугаар сарын 08,09-ний өдрүүдэд Жи Эс Монголиа ХХК-тай хамтран БНСУ-аас зорин ирсэн 78 жуулчдын хамруулан Монос, Шинэс, Хайлаас, Тавилгана зэрэг долоон зүйлийн 100 гаруй мод тарьсан байна. 2024 оны хоёрдугаар ээлжийн Жуулчин төгөлд мод тарих арга хэмжээг аялал жуулчлалын салбарынх 70 жилийг ойг тохиолдуулан 9 сарын 29-ний өдөр амжилттай зохион байгууллаа. Нийтдээ аялал жуулчлалын салбарын 150 орчим (салбарын оюутнууд 80) ажилчид албан хаагчдын төлөөлөлүүд 16орчим сая төгрөгийн үнэ бүхий 326 мод, бут, сөөгийг (Гацуур – 120 Нарс-12 Шинэс-13 Хус-26 Гүйлс-40 Буйлс-16 Нохойн хошуу-16 Тэхийн шээг-23 Голт бор-11 Монос-44) амжилттай тарьлаа. | | |
| 9. | **Арга хэмжээ-2.3:** Улаанбаатар хотын аяллын шинэ бүтээгдэхүүнийг бий болгож аялал жуулчлалын эргэлтэд оруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 1 | 2 | Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/849 захирамжийн хүрээнд Улаанбаатар хот болон хот орчимд эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, жуулчдын зорин очих газар болон маршрутын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх ажлын хүрээнд алхалтын 15 маршруутыг нээж, зам маршутыг заах мэдээллийн 50 самбарыг байршуулсан. Үүнд: | 2024.06.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 1. Хүннү цогцолбор<br>2. Их баян санзай<br>3. Хадат<br>4. Хайрхан хөгжлийн төв-Шүтээн цогцолбор<br>5. Асралт хайрханы бараа<br>6. Ямаат уулын алхалтын зам<br>7. Тэрэлж алхалт<br>8. Зүрхэн оргил<br>9. Шадивлан-Чингэлтэй<br>10. Бэлх<br>11. Доод салхитын зогсоол-зүрх уул<br>12. Хандгайт<br>13. Хиймэл ойн зурвас<br>14. Хиймэл нуур-хадтай ой<br>15. Хятад гэх мэт маршрутуудыг нээсэн байна.<br>2024оны 03 дугаар сарын 03-ний өдөр Олон улсын хүүхдийн Найрамдал төвөөс Жавхлант өртөө хүртэлх маршрут замын дагуу анх удаа амжилттай зохион байгуулсан. Тус арга хэмжээнд нийслэл хотын алхагчдаас гадна 10-н аймгийн нийт 300гаруй явган алхагчид зорин ирж оролцсон. | | |
| 3.4.2.2.ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНГҮҮДЭД ОРОЛЦОЖ УЛААНБААТАР ХОТЫГ СУРТАЛЧИЛАН ТАНИУЛНА. | | | | | | | |
| 10. | **Арга хэмжээ-3.1:**<br>"Улаанбаатар травэл экспо 2024" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/585 дугаар захирамж, тус газрын даргын 2024 оны А/16 дугаар тушаалын дагуу "Улаанбаатар травел экспо-2024" аялал жуулчлалын үзэсгэлэнг 2024 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Мишээл экспо төвд 10 дахь жилдээ Улаанбаатар аялал жуулчлалын холбоо ТББ-тай хамтран зохион байгуулдаа. Үзэсгэлэнгийн үйл ажиллагаанд БНСУ-ын КТО Улаанбаатар | 2024.05.24<br>2024.05.26 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | суурин төлөөлөгчийн газрын харъяа 17 байгууллага, БНХАУ-н Монгол улс дахь төлөөлөгч ЗАНАДУ ТРАВЕЛ ХХК, 21аймгийн төлөөлөл болох Өмнөговь, Завхан, Увс, Ховд, Дархан зэрэг аймгууд өөрсдийн аймгийн аялал жуулчлалын талаарх мэдээллийг 3өдрийн турш өгч оролцлоо. Мөн дэмжигч байгууллагаар Улаанбаатар театр ОНӨТҮГ-н уран бүтээлчид бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцлоо. Тус арга хэмжээнд Нийслэлийн төсвөөс нийт **27,500,000** төгрөгийг төсөвлөснөөс **27,500,000** төгрөгийг зарцуулсан. Үүнд:<br>- Маркетинг сурталчилгаа, хэвлэл мэдээлэл талбайн тохижилтийн ажилд 4,000,000 төгрөг,<br>- Тайз хөгжим, талбайн түрээс, гадна болон дотоод тохижилтийн ажилд 18,500,000 төгрөгийг<br>- "Жим" аяллын хөтөч сэтгүүлийн хэвлэлтэд 5,000,000 тус тус зарцуулав. | | |
| 11. | **Арга хэмжээ-3.2:**<br>"Ай Ти Эм 2024" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцох | | | | Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах, иргэд, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах зорилгоор 2024 оны 10 дугаар сарын 25, 26, 27--ны өдрүүдэд Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулагдаж дууссан. ITM-МОНГОЛИА 2024 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн "ҮНДЭСНИЙ СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛ" | 2024.10.25-<br>2024.10.27 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | уриа нь дор 25 дахь жилдээ зохион байгуулагдлаа. Уг арга хэмжээнд манай Улаанбаатар хотын автобусыг сурталчлан, сурталчилгааны үйл ажиллагаанд 20,600,000 төгрөгийг зарцуулсан.<br><br>Манай газар "Шилдэг тохижилттой бүүт"-ээр шалгарсан. Мөн арга хэмжээнд дараах материалуудыг иргэд олон нийтэд түгээж, хотын аяллын автобус болон байгууллагын үйл ажиллагааг танилцуулсан.<br><br>• Улаанбаатар сэтгүүл -300 ширхэг<br>• Хоггүй аялъя уриалга бүхий номын хавчуурга -1000 ширхэг<br>• Улаанбаатар хотын аялал танилцуулга-1500 ширхэг /Англи, монгол/<br>• Сити тур автобусны хэлбэртэй утасны наалт-200 ширхэг<br>• Хотын соёл, Хоггүй аялал машины дугаар тэмдэглэгч-500 ширхэг<br>• Наадам /festival/ танилцуулга брошюр-1000 ширхгийг тус тус иргэд жуулчдад тарааж арга хэмжээнд оролцож буй 200 гаруй байгууллага1500 гаруй иргэд мэдээллээ сурталчлан хүргэсэн. Манай мэдээллийн төвөөр дамжуулан үйл ажиллагаагаа сурталчлуулахаар 3 жуулчны бааз 2 тур оператор 1 аялал жуулчлалын байгууллага, 2 аймаг сурталчилгааны материал өгсөн. | | |
| 3.4.4.1 "Найрсаг Улаанбаатар арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12. | **Арга хэмжээ-3.3:** Жуулчдад зориулсан шөнийн худалдаа, үйлчилгээний гудамжтай болох | Гудамжны тоо | - | 1 | Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороонд байрлах Нийслэлийн өмчийн III байр буюу "Урт цагаан" худалдаа, үйлчилгээний төвийн дахин төлөвлөлтийн талаар иргэдээс санал авахад 96 хувь нь цэцэрлэгт хүрээлэн байгуулахыг дэмжсэнээр тус барилгыг буулгаж, чөлөөлсөн.<br>Иргэдийн санал хүсэлтийн дагуу чөлөөлсөн 1.3 га талбайд авто машины далд зогсоолтой, дээрээ ногоон байгууламжтай цэцэрлэгт хүрээлэн байгуулах зураг төсөл боловсруулсан байна. Зураг төсөлд гурван давхар үйлчилгээний төв, далд, ил зогсоол, задгай мини театр, дугуйн зогсоол, усан оргилуур зэргийг төлөвлөсөн байна.<br>Тус гудамжийг жуулчны гудамж болгон төлөвлөх талаар саналыг Зураг төслийн хүрээлэнд хүргүүлэн ажиллав.<br>Мөн Налайх дүүргийн 3 дугаар хороонд "Плэй-тайм" арга хэмжээг зохион байгуулдаг талбайруу дэд бүтэц татах автозам тавих асуудлын талаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлсэн. | 2024.01.01-2024.12.31 | - |
| 13. | **Арга хэмжээ-3.4:** Жуулчин тээврийн автобусны зогсоолын асуудлыг шийдвэрлүүлэх ээр холбогдох байгууллагуудад санал хүргүүлэх | Автобусны зогсоолын тоо | - | 1 | Жуулчдад зориулсан шатл бус үйлчилгээг гаргахаар холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийж ажиллав, Уулзалтын хүрээнд UBUS автобус түрээсийн байгууллагатай хамтран ажиллахаар санал боловсруулж шаардлагатай байгаа техник хэрэгслүүдийг нэмэгдүүлэх ажлыг нийслэлийн удирдлагуудад танилцуулан ажиллав. Мөн энэ хүрээнд нийтийн тээвэрт саад болохгүйгээр жуулчны автобус тогтмол зогсдог зогсоолуудыг төлөвлөн томоохон зочид буудлуудын дэргэд тогтмол цагт зогсох маршрутыг боловсруулан ажиллав. Уг ажлын хүрээнд Нийслэлийн нийтийн тээврийн газарт санал тавьсанаар "Чингис | 2024.01.01-2024.12.31 | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хаан" олон улсын нисэх буудлаар үйлчлүүлж буй иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх зорилгоор 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс нийтийн тээврийн автобус дараах гурван чиглэлийн дагуу үйлчилгээ үзүүлж байна. X:19 "Чингис хаан нисэх буудал-Сүхбаатарын талбай"<br>X:20 "Чингис хаан нисэх буудал-5 шар" чиглэлүүдэд 06:20 цагаас 22:30 цагийн хооронд үйлчилж байна.<br>X:19 "Чингис хаан нисэх буудал-Сүхбаатарын талбай" чиглэлд том хүн 15000 төгрөгөөр, хүүхэд 7000 төгрөгөөр,<br>X:20 "Чингис хаан нисэх буудал-5 шар" чиглэлд том хүн 15000 төгрөгөөр, хүүхэд 7000 төгрөгөөр мөн картаар үйлчлүүлэх боломжтой. | | |
| 14. | **Арга хэмжээ-3.5:**<br>Түүхэн дурсгалт газруудад бүтээн байгуулалт хийж, соёлын үл хөдлөх дурсгалуудыг түшиглэн он цагийн аялал зохион байгуулах | Маршрутын тоо | - | 1 | Сити тур төслийн хүрээнд Улаанбаатар хотын аяллыг нийт 27 маршрутын дагуу хийхээр төлөвлөн ажиллаж байна.Эдгээр маршрутад "Их тэнгэрийн амны хадны зураг", "Богд хааны ордон музей", "Туулын хар түнийн ордны туурь", "Бэлхийн амны Хүннүгийн Язгууртаны булш" гэх мэт түүхэн дурсгалт газруудыг оруулахаар судлан ажиллаж байна.<br>Нийслэлийн хүүхэд гэр бүл хөгжлийн газартай хамтран Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 06-р сарын 01-ний өдөр Улаанбаатар хотын аяллыг зохион байгуулсан. Тус аяллын маршрутад "Богд хааны ордон музей", "Их тэнгэрийн амны хадны зураг"-тай танилцах аяллыг амжилттай зохион байгуулсан. Мөн Монголын явган алхалтын холбоотой хамтран "Түүх соёлын жимээр аялсан нь" танин мэдэхүйн аяллыг зохион | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууласан. НЗДТГазраас "Ирээдүйн хотын иргэн" арга хэмжээг 2024оны 10дугаар сарын 04-ны өдрөөс 12 дугаар сарын 02-ны өдөр хүртэл зохион байгуулсан. Уг арга хэмжээний үеэр Нийслэлийн ЕБС-н нийт 8-н сургуулийн 640 сурагчдыг хамруулан Хүүхдийн урлан бүтээх төв, "Минж нутагшуулах, үржүүлэх төслийн нэгж" ОНӨҮГ, Ус сувгийн удирдах газар ОНӨҮГ, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газар, Гэрлэх ёслолын ордон, Монголын Үндэсний Музей зэрэг төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл зэрэг танилцах аяллыг хийсэн. | | |
| ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР | | | | | | | |
| Газрын дүрмийн 4.1.10. Нийслэлийн аялал жуулчлалын нөөцөд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах | | | | | | | |
| 15. | **Арга хэмжээ-4.1:** Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр 21 аймгийн аялал жуулчлалын газартай хамтран ажиллах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 100% | 100% | Монгол Улсын 21 аймгийн аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүдтэй мэдээлэл солилцох, хамтран ажиллахаар цахим бүлгэм байгуулж, цаг тухай бүрд мэдээ мэдээллийг солилцож хамтран ажиллаж байна. "Улаанбаатар травел экспо-2024" үзэсгэлэнгийн хүрээнд 10 аймгийн аялал жуулчлалын мэргэжилтнүүдтэй уулзаж санал солилцсон.<br>Мөн 21 аймгийн аялал жуулчлалын байгууллагуудаас 2024 онд хийгдэхээр төлөвлөж байгаа соёлын арга хэмжээ, болон үйлчилгээний байгууллагуудын мэдээ, мэдээлэл танилцуулга, тараах материал зэргийг жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдэд байршуулж иргэд жуулчдад түгээн ажиллаж байна. | 2024.01.01<br>2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийт 9 аймгийн 30 гаруй байгууллагын мэдээлэл шинэчлэгдэн нэгтгэгдсэн байна. Бусад аймгуудын аялал жуулчлал хариуцсан мэргэжилтнүүдэд мэдээллийг цахимаар хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 4.1.12. Газрын дүрмийн Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын мэдээллийн санг хөтлөх; | | | | | | | |
| 16. | **Арга хэмжээ 5.1:** Хариуцсан ажлын хүрээнд холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Байгууллагаас зохион байгуулсан арга хэмжээнүүдэд жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийн цэгийг ажиллуулж иргэд жуулчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн нэгжийн дарга, мэдээллийн төвүүд хариуцсан менежерт болон холбогдох мэргэжилтнүүдэд өгч ажиллаж байна. | 2024.01.01 2024.12.31 | 100% |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар 1. Койка-н сайн дурын ажилтанг хариуцаж ажиллах | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Койка-н 160-р ээлжийн сайн дурын ажилтануудаас манай газарт хуваарьлагдан ирсэн ажилтанг орчиндоо дасан зохицох байгууллагатай танилцуулах, байр олоход туслах, монгол хэлний хичээл заах зэрэг ажлуудыг хийсэн. | 2024.01.20 2024.04.01 | 100% |
| 2. | Үүрэг даалгавар 2. Сэлбэ голын эрэг дагуух цэвэрлэгээ | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Сүхбаатар дүүргийн 14-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Сэлбэ голын эрэг дугуу цэвэрлэгээ хийсэн. | 2024.05.16 | 100% |
| 3. | Үүрэг даалгавар 3. Гадаад харилцааны яамны дэргэдэх талбайн цэвэрлэгээ | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Жил бүр нийслэлийн хэмжээнд зохион байгуулдаг хаврын их цэвэрлэгээний хүрээнд дөрөвдүгээр сарын 11-13-ны өдрүүдэд “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчид Гадаад харилцааны яамны урд уулзвараас Төв номын сангийн | 2024.04.11 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хойд уулзвар хүртэл хог хаягдлыг цэвэрлэн, дугуйн зогсоол, тамхины цэг, сандал зэргийг угааж, цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлсэн. | | |
| 4. | Үүрэг даалгавар 4. Сансрын И-мартын явган хүний зам цэвэрлэх | Гүйцэтгэлийн хувь | - | 100% | Сансрын И-мартын явган хүний замын цасыг цэвэрлэж иргэдийн тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн. | 2024.01.10 | 100% |
| 5. | Үүрэг даалгавар 5. Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал тууж хашаанд түр саатуулах үйл ажиллагааны удирдамж болон нийслэлийн харьяа байгууллагын албан хаагчдыг дайчлан ажиллуулах | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн "Журмын хэрэгжилтийг хангуулах тухай" А/226 дугаар захирамжаар батлагдсан Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал тууж хашаанд түр саатуулах үйл ажиллагааны хүрээнд Баянгол дүүргийн 15,16,17,18-р хорооны нутаг дэвсгэрт ажиллав. | 2024.03.09 | 100% |
| 6. | Үүрэг даалгавар 6. Улаанбаатар хот орчмын явган алхалтын замуудын тохижилтыг шалгах | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | Улаанбаатар хот орчмын явган алхалтын замууд болох Ар зайсангийн амнаас Дугуй зайсан, Чингэлтэй уул, Баянзүрх хайрхан уул, Сонгино хайрхан уул, Богдхан уулын Төр хурахын ам зэрэг газруудад хийсэн тохижилтын ажлын тэмдэг тэмдэглэгээ, сүүдрэвч амралтын цэгүүдийг нэг бүрчлэн шалгах ажлыг хийсэн. | 2024.11.01 | 100% |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Төрийн албан хаагчийн нутгийн захиргаанаас | Тоо | - | 3 | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй төрийн албан хаагчийг чадавхжуулах | 2024.01.01 2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зарлагдсан сургалтанд хамрагдах | | | | "7:4:10" сургалтад долоо хоног бүрийн пүрэв гаригт цахимаар нийт 2 удаагийн сургалт хамрагдсан. Нийслэлийн нутгийн захиргааны албан хаагчдад зориулсан "Авлигын эсрэг" сургалтад хамрагдаж ойлголт мэдээлэл авсан. Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүй зэрэг сургалтуудад хамрагдав. | | |
| 2. | Монгол хэл бичгийн тооны чадвараа дээшлүүлж, Солонгос хэлний танхимын сургалтад хамрагдаж дээд шатны ярианы хэл сурсан байна. | Тоо | - | 2 | Монгол хэл бичгийн "Эргэм Боловсролын Төв"-ийн сургалтад цахимаар болон танхимаар хамрагдаж үндэсний хэл бичгээрээ уншиж, бичих, тоо тоолох зэргийг сурч байна. Солонгос хэлний цахим болон сургалт | 2024.01.01 2024.12.31 | 100% |
| 3 | Төрийн худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдах | | | | Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 04-р сарын 05,08-09-ний өдрүүдэд Төрийн худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдав. | 2024.04.05,08-09 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

АЯЛЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХӨГЖҮҮЛЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ........................ Б.ОТГОНБИЛЭГ 2024.12.09

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*

18

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*4 дүгээр хавсралт*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: Б.Отонбилэг

Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 02 сарын 27 өдөр

Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн ✓ 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай | Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар |
|---|---|---|---|
| | **Зорилт 1.** “ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АЖЛЫН ХҮРЭЭНД” | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>“Улаанбаатар өвлийн явган алхалт” арга хэмжээг зохион байгуулах | | Арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангах |
| | **Зорилт 2.** “ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР” | | |
| 1. | Арга хэмжээ 2.1<br>2024 онд зохион байгуулах эвент, арга хэмжээний хуваарь, видео шторк гарган олон нийтэд хүргэх | | |
| 2. | Арга хэмжээ 2.2<br>Эвент, арга хэмжээнд жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуй нэгжүүдийг хамруулах | | |
| | **Зорилт 3.** “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | |
| 1. | Хариуцсан ажлын хүрээнд холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх | | |

**ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:**

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга .................................... / С.Туул /

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*4 дүгээр хавсралт*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: Б.Отгонбилэг
Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 04 сарын 29 өдөр
Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн ✓ 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай | Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар |
|---|---|---|---|
| | **Зорилт 1.** " БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АЖЛЫН ХҮРЭЭНД" | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>"Хөдөлмөрийн яармаг" арга хэмжээг зохион байгуулах | | [illegible] |
| | **Зорилт 2.** "ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР" | | |
| 1. | Арга хэмжээ 2.1<br>2024 онд зохион байгуулах арга хэмжээний хуваарь гарган олон нийтэд хүргэх | | |
| 2. | Арга хэмжээ 2.2<br>Эвент, арга хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуй нэгжүүдийг хамруулах | | |
| | **Зорилт 3.** "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | |
| 1. | Хариуцсан ажлын хүрээнд холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх | | |

**ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:**

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга .................................. / С.Туул /

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*4 дүгээр хавсралт*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: Б.Отгонбилэг
Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 08 сарын 28 өдөр
Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай | Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар |
|---|---|---|---|
| | **Зорилт 1.** " БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АЖЛЫН ХҮРЭЭНД" | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>"Улаанбаатар олон улсын явган аяллын фестиваль" арга хэмжээг зохион байгуулах | | Бизнес аялын төлөвлөгөө гаргах |
| | **Зорилт 2.** "ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР" | | |
| 1. | Арга хэмжээ 2.1<br>2024 онд зохион байгуулах эвент, арга хэмжээний хуваарь, видео шторк гарган олон нийтэд хүргэх | | |
| 2. | Арга хэмжээ 2.2<br>Эвент, арга хэмжээнд жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуй нэгжүүдийг хамруулах | | |
| | **Зорилт 3.** "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | |
| 1. | Хариуцсан ажлын хүрээнд холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх | | |

**ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:**

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга ........[signature]........ / С.Туул /

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*4 дүгээр хавсралт*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: Б.Отгонбилэг
Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 04 сарын 25 өдөр
Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай | Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар |
|---|---|---|---|
| **Зорилт 1.** " БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АЖЛЫН ХҮРЭЭНД" | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>Налайх дүүрэг дэх "Нэг жуулчин-нэг мод" жуулчны төгөлд мод тарих арга хэмжээг зохион байгуулах | | Аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран ажиллах |
| **Зорилт 2.** "ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЭР" | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1<br>2024 онд зохион байгуулах эвент, арга хэмжээний хуваарь, гарган олон нийтэд хүргэх | | |
| 2. | Арга хэмжээ 2.2<br>Эвент, арга хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэд, аж ахуй нэгжүүдийг хамруулах | | |
| **Зорилт 3.** "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | |
| 1. | Хариуцсан ажлын хүрээнд холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх | | |

**ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:**

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга ............................ / С.Туул /

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*4 дүгээр хавсралт*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Албан хаагчийн овог, нэр: Б.Отгонбилэг
Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 05 сарын 20 өдөр
Ярилцлагын хэлбэр: 1.Биечлэн ✓ 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хангалттүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай | Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар |
|---|---|---|---|
| **Зорилт 1. “ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АЖЛЫН ХҮРЭЭНД”** | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1<br>“Улаанбаатар травэл экспо 2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах | | UBUS, Olle хамтрах зохион байгуулалт хийх |
| **Зорилт 2. “ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР”** | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1<br>2024 онд зохион байгуулах эвент, арга хэмжээний хуваарь, видео шторк гарган олон нийтэд хүргэх | | |
| 2. | Арга хэмжээ 2.2<br>Эвент, арга хэмжээнд жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэд, аж ахуй нэгжүүдийг хамруулах | | |
| **Зорилт 3. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | |
| 1. | Хариуцсан ажлын хүрээнд холбогдох бүх төрлийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх | | |

**ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:**

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга ..............(гарын үсэг).............. / С.Туул /

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )*

919